

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр
Тендерийн дугаар: МРЦМ/202212214

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь “Дархан-Бор-Өндөр чиглэлийн 44км ус хангамжийн шугам сүлжээний шинэчлэлийн ажлын зураг, төсөв” зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет” ТӨҮГ-ын Дархан-Бор-Өндөр чиглэлийн 44км ус хангамжийн шугам сүлжээний шинэчлэлийн ажлын зураг, төсөв хийлгэх үйлчилгээ болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга,
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар,
 - Тусгай зөвшөөрөл
 - Сүүлийн 2 жилд ус хангамжийн шугам сүлжээний шинэчлэлийн ажлын зураг, төсөв хийж байсан туршлагын мэдээлэл /гэрээ, гэрээ дүгнэсэн актын хамт/,
 - Татварын өргүй тухай тодорхойлолт зэргийг ирүүлнэ.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2022 оны 05 дугаар сарын 19–ны өдрийн 13 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 09 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.